

Дана + 20 жил буюу Нүүдэлчин ард түмний тунхаг бичиг

Нутгийн нүүдэлчин уугуул ард иргэд, Байгаль хамгаалал, Тогтвортой хөгжил ба Уур амьсгалын өөрчлөлт Данагийн тунхаглалаас хойших 20 жил

Йорданы Хашемын Хаант Улсын Вади Дана - байгалийн нөөц газар, 2022 оны 9-р сарын 10

ХУРААНГУЙ

Нутгийн уугуул, уламжлалт, нүүдэлчин, овог аймгийн зохион байгуулалтаар амьдардаг иргэдийг¹ хамруулсан “нүүдэлчин ард иргэд”-ийн төлөөлөл болсон биднээс гадна энэ талаар тусгайлан санаа тавьж ажилладаг судлаач, дадлагажигч нар, Данагийн тунхаглал² гарсанаас хойш 20 жилийн дараа өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, ирээдүйн төлөвлөгөөгөө боловсруулахаар Йорданы Вади Дана хэмээх байгалийн нөөц газарт хуран цуглаад байна.

Бидний хүрээний буюу нүүдэлчин ард түмний тоонд дэлхий даяарх хэдэн зуун сая хүмүүс багтдаг. Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлт, газар нутаг болон усны нөөцөө бусдын ашиг сонирхолын гарт алдах, ихэвчлэн тааламжгүй нөхцөл бүхий бэлэн мөнгөний эдийн засгийн харилцаанд хэт оролцох зэргээс болж бидний хүрээлэн буй орчин, амьдралын хэв маяг доройтож байна. Хэдийгээр элдэв бодлого, хууль тогтоомжуудын зэрэгцээ, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенциудыг³ соёрхон баталсан боловч соёлын хувьд ялгаварлан гадуурхах үзлүүд хэвээр байна.

Бид засгийн газруудыг бодлогоо өөрчлөхийг уриалж байна. Юуны өмнө өөрсдийн нутаг дэвсгэртээ хүртээмжтэй орших, нөөц баялгаа хамтран ашиглах зэрэг бидний уламжлалт заншлын хэм хэмжээнд үндэслэсэн эрхийг хүлээн зөвшөөрч, албан ёсоор баталгаажуулах нь зүйтэй. Хоёрдугаарт, уламжлалт эрх мэдэл болон зан заншлын хэм хэмжээнд үндэслэсэн хууль тогтоомжийг хүлээн зөвшөөрч, ингэснээр шийдвэр гаргах үйл ажиллагаанд нүүдэлчин ард түмнийг шударгаар оролцуулах хэрэгтэй. Гуравдугаарт, өсвөр үеийнхнийг уламжлалт мэдлэг, өөрсдийн жинхэнэ өвөрмөц онцлогийг эрхэмлэн дээдлэхэд чиглэсэн, соёлын мэдрэмжтэй боловсролд оролцуулахыг дэмжих явдал юм.

Бидний эрх, уламжлалт мэдлэг, заншлын хэм хэмжээнд үндэслэсэн удирдан зохицуулах арга түршлагыг хүндэтгэж мөн газар нутгаа болон хүний эрхийг хамгаалагч нар нь манай нутгийн ард иргэд болон нийгмийн хувьд⁴ ямар чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг хүлээн зөвшөөрөхийг **бид байгаль хамгаалагчид болон байгаль орчны мэргэжилтнүүдэд уриалж байна.** Бид гэрээ байгуулсан бүх талуудад байгуулсан гэрээнүүдийг нь дахин сануулж, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг хүсч байна.⁵ Бид тэдэнд, Вакатане механизмийг (Whakatane Mechanism) хүчин төгөлдөр болгож, уг механизмуудыг боловсруулж, ингэснээр дээрх нөлөөнд өртсөн ард иргэд өөрсдийн санаа зовоож буй асуудлаа гарган дэвшүүлж, мөн тэдэнд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, нөхөн олговор авах, эвлэрүүлэн зуучлуулах үйлчилгээний замаар асуудлаа шударгаар шүүлгүүлж, шийдвэрлүүлэх бололцоо бүрдэхүүлэхийг уриалж байна.

¹ IFAD 2009. Engagement with Indigenous Peoples Policy, IFAD, Rome.

² The Dana Declaration, Dana + 10 and Dana + 20 fully endorse the implementation of the UN Declaration on the Rights of Indigenous Peoples. See the Dana Declaration website: <https://www.danadeclaration.org/>.

³ And other global instruments that address Indigenous Peoples' collective rights such as UNDRIP, ILO 169, and VGGT.

⁴ UN Declaration on Human Rights Defenders.

⁵ Endorsement Dana Declaration in 5.2.7 and in 4th World Conservation Congress in Barcelona. In particular, CBD COP 7 Decision 28, COP 10 Decision 2, COP 12 Decision 12, COP 14 Decision 8, all with their respective annexes; Key Messages of the Inter-Governmental Panel on Biodiversity and Ecosystem Services (IPBES) - IPBES 'Key messages' A6, B6 and D5 of Global Assessment.

Бид **корпорацуудыг** манай нутгийн ард иргэдийн эрхийг хүндэтгэж, Акве: Кон (Akwe: Kon)-ийн удирдамжийн⁶ дагуу нийгэм, эдийн засаг, соёл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг тэдний бүрэн оролцоотой явуулахыг **уриалж байна**. Аливаа төсөл хөтөлбөрүүд нь зөвхөн бидний чөлөөт, урьдчилж мэдээлэл авсны үндсэн дээр өгөх зөвшөөрөл (FPIC)-ийг авсаны үндсэн дээр, мөн өөрсдийн сонгосон төлөөлөгчдийн⁷ оролцоотойгоор хэрэгжих ёстой. Корпорациуд нь учирсан аливаа алдагдал хохирлыг шударгаар нөхөн төлж барагдуулах ёстой.

Бид энэхүү тунхаглалаа хамтран ажиллах нээлттэй урилга байдлаар санал болгож байгаа бөгөөд нүүдлийн амьдралын хэв маяг болон тэдгээр нүүдэлчин ард түмэн манай дэлхийн ирээдүйн хувьд ямар чухал болохыг сайтар ойлгоосой хэмээн хүсч байна.

⁶ <https://www.cbd.int/doc/publications/akwe-brochure-en.pdf>

⁷ <https://www.fao.org/3/i3496e/i3496e.pdf>